

# West Northfield D31 Гүнзгийрүүлсэн Сургалтын Хөтөлбөр (ALP)-ийн Тайлбар Болон Хичээлүүд

## Хөтөлбөрийн Тайлбар

District 31 нь бүх сурагчдад зориулсан ялгавартай, гүнзгийрүүлсэн боловсрол олгох ёстой гэдэгт итгэдэг. Гүнзгийрүүлсэн Сургалтын Хөтөлбөрийн (ALP) зорилго нь математик, англи хэлний түвшингээрээ дунджаас дээш сурагчдад математик, англи хэлийг гүнзгийрүүлж мөн түргэвчлэн үзэх боломж олгодог.

- Дөрөвдүгээр ангийн бүх сурагчид гүнзгийрүүлсэн хөтөлбөрт хамрагдах боломжтой. Энэхүү хөтөлбөр нь хичээлийн жилийн туршид, шинэ нэгж эхлэх болгонд багш сурагчдаас түвшин тогтоох шалгалт авсаны дараагаар дунджаас дээш сурагчдыг нэг бүлэг болгоно.
- Тавдугаар ангиас эхлэн сурагчидын академик шалгалтын оноо (NWEA MAP), танин мэдэхүйн шалгалтын оноо (CogAT), багшийн өгсөн сэтгэгдэл (SIGS) 3-ыг нийлүүлсэн онооны дүнгээс шалтгаалан тэднийг энэхүү математик, англи хэлний түргэвчилсэн хөтөлбөрт орох үгүй эсэх нь шийдэгдэнэ.

## Мэдээлэл Цуглуулалт Болон 5-р Ангийн Хуваарьлалтын Алхамууд

### Алхам 1: Сурагчдын Түвшин Тогтоолт

- Намар/Өвөл/Хавар: 1-8 дугаар ангийн сурагчид NWEA MAP шалгалтаа авч дуусгасан байна.
- Гуравдугаар сар: 3, 5-р ангийн сурагчид анин мэдэхүйн шалгалтаа (CogAT) авч дуусгасан байна.
- Гуравдугаар сар: 4, 5-р ангийн сурагчдын багш нар SIGS бөглөж дуусгасан байна.



### Алхам 2: Сурагчдын Түвшингийн Ангийн Хуваарьлалт

- Тавдугаар Сар: NWEA MAP, CogAT, SIGS-ын нийлбэр оноог түвшингийн ангийн хуваарьлалтын матрицтай (рубриктэй) харьцуулан үзээд, Гүнзгийрүүлэн Сурах Хөтөлбөрт (ALP) аль оюутан тэнцэх эсэхийг нь тогтооно. Жич: Улсын NWEA MAP шалгалтын хувийн жингийн хамгийн өндөр 2 оноог авч, дундажийг нь Матриц Оноонд хэрэглэдэг.
- Тавдугаар Сар: Багш нар ...ангийн хувиарлалтыг хараад, дараа нь өөрсдийнхөө санал бодолыг энэ талаар өгнө.
- Зургадугаар Сар: 5-р болон 6-р ангид орох сурагчдын ар гэрийнхэнд тэд аль ALP ангид хуваарьлагдсан тухай захидал илгээнэ. \*Нэгж (unit) бүрийн эхэнд багш 4-р ангийнханаас түвшин тогтоох шалгалт авч, дунджаас дээш түвшинтэй сурагчидыг нэг бүлэг үүсгэн, 4-р ангийн гүнзгийрүүлсэн хөтөлбөртэй ангид хуваарилна.

Жич: Сурагч 5-р ангиасаа эхлэн бүтэн жилийн ALP хичээлд бэлэн гэдгээ харуулсны дараа ангийн ажилтай холбоотой асуудал гараагүй бол тухайн сурагч ALP-д үлдэнэ.



### Алхам 3: Ирэх хичээлийн жилд ALP-т хувиарлагдсан сурагчийн хувьд;

- Хэрвээ сурагч, сурагчийн эцэг эх хуваарьлагдсан ангидаа санал нэг байгаа бол тэдний зүгээс юу ч хийх хэрэггүй.
- Хэрэв эцэг эх эсвэл сурагч ALP-д элсэхийг хүсэхгүй байгаа бол захиралд бичгээр хүсэлтээ өгнө үү.



### Алхам 3: Ирэх хичээлийн жилд ALP-т хувиарлагдаагүй сурагчийн хувьд;

- Ялгавартайгаар болон/эсвэл тэднийг түвшингээр нь нэг бүлэг үүсгэх зарчмаар ангийн хичээл тухайн хичээлийн туршид үргэлжлэн явагдах болно.
- Хэрвээ сурагч, сурагчийн эцэг/эх аль нэг нь ALP ангид орохыг хүсвэл, лавлагааны хуудас бөглөж өгөөрэй. Лавлагааны хуудасыг сурагч 1 жилд, 1 хичээлд, 1 удаа бөглөж өгнө.

Ийнхүү сурагч бүрийн мэдээлэл цуглармагц, доор дүрсэлсэн матрицуудыг удирдлага болгон ашиглаж, 5-р ангийнхны ALP ангийн хуваарьлалт хийнэ.

ALP Math Matrix								
NWEA- Math National Percentile- average of 2 highest from F/W/S		CogAT-NonVerbal Grade Percentile Rank		CogAT- Quantitative Grade Percentile Rank		SIGS- Mathematics Percentile Rank		
85-89%ile	3 pts	85-89%ile	1 pts	85-89%ile	1 pts	85-89%ile	3 pt	
90-94%ile	5 pts	90-94%ile	2 pts	90-94%ile	2 pts	90-94%ile	5 pts	
95-99%ile	8 pts	95-99%ile	3 pts	95-99%ile	3 pts	95-99%ile	8 pts	
9-16: 5th Enriched /6th-8th Single Accelerated 17 and up: 5th Accelerated/6th-8th Double Accelerated							<b>TOTAL SCORE</b>	

ALP ELA Matrix								
NWEA- Reading National Percentile- average of 2 highest from F/W/S		CogAT-NonVerbal Grade Percentile Rank		CogAT- Verbal Grade Percentile Rank		SIGS- Language Arts Percentile Rank		
85-89%ile	3 pts	85-89%ile	1 pt	85-89%ile	2 pts	85-89%ile	1 pt	
90-94%ile	5 pts	90-94%ile	2 pts	90-94%ile	4 pts	90-94%ile	2 pts	
95-99%ile	8 pts	95-99%ile	3 pts	95-99%ile	6 pts	95-99%ile	3 pts	
12 or higher to qualify							<b>TOTAL SCORE</b>	

### Гүнзгийрүүлсэн хөтөлбөртэй анги гэж юу вэ?

Энэ ангид сурагчидын шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхийн тулд стандарт материалаас арай илүү гүнзгийрүүлсэн түвшинд хичээлүүдээ заадаг. Энэ сургалтын хөтөлбөр нь хэвтээ (horizontal) чиглэлийг онцолдог.

### Түргэвчилсэн хөтөлбөртэй анги гэж юу вэ?

Энэ анги нь хичээлүүд нь түргэвчилсэн хөтөлбөрөөр орох буюу дараагийн ангийн хичээлүүдийг судална гэсэн үг. Энэ сургалтын хөтөлбөр нь босоо (vertically) чиглэлийг онцолдог.

### Анги Бүрийн Гүнзгийрүүлсэн Сургалтын Хөтөлбөр

Англи хэл	
Ангиуд	Тайлбар
Гүнзгийрүүлсэн ELA 4	Дундажаас дээш сурагчдын бүлэг үүсгэн, тэдэнд CCSS 4-р ангийн стандарт ELA хичээлийг гүнзгийрүүлэн заана.
Түргэвчилсэн ELA 5	CCSS 5-р бас 6-р ангийн стандарт ELA хичээл заана.
Түргэвчилсэн ELA 6	CCSS 7-р ангийн стандарт ELA хичээл заана.
Түргэвчилсэн ELA 7	CCSS 8-р ангийн стандарт ELA хичээл заана.
Түргэвчилсэн ELA 8	CCSS 9-р ангийн стандарт ELA хичээл заана.

Математик		
Ангиуд	Хөтөлбөр	Тайлбар
4	Гүнзгийрүүлсэн Математик 4	Дунджаас дээш түвшингийн сурагчдын бүлэг үүсгэн, MCCSS-ийн 4-р ангийн стандарт математикийн хичээлийг гүнзгийрүүлэн заана

5	Гүнзгийрүүлсэн Математик 5	CCSS 5-р ангийн стандарт математикийн хичээлийг гүнзгийрүүлэн заана
	Түргэвчилсэн Математик 5	CCSS 5-р бас 6-р ангийн стандарт математикийн хичээл заана
6	Нэг Анги Ахисан Түргэвчилсэн Математик 6	CCSS 6-р бас 7-р ангийн стандарт математикийн хичээл заана
	Хоёр Анги Ахисан Түргэвчилсэн Алгебр 6	CCSS 7-р бас 8-р ангийн стандарт математикийн хичээл заана
7	Нэг Анги Ахисан Түргэвчилсэн Математик 7	CCSS 7-р бас 8-р ангийн стандарт математикийн хичээл заана
	Хоёр Анги Ахисан Түргэвчилсэн Алгебр 7	CCSS ахлах сургуулийн стандарт алгебр хичээл заана
8	Нэг Анги Ахисан Түргэвчилсэн Алгебр 8	CCSS ахлах сургуулийн стандарт алгебрийн хичээл заана
	Хоёр Анги Ахисан Түргэвчилсэн Геометр 8	CCSS ахлах сургуулийн стандарт геометрийн хичээл заана. Жич: Энэ ангид орохын тулд Алгебр 1 хичээлийг авсан байх шаардлагатай.

Гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрүүдийн талаар асуулт байна уу? [mknapik@district31.net](mailto:mknapik@district31.net) хаягаар сургалтын хөтөлбөр, заавар хариуцсан ахлах туслах Мег Кнапиктай холбогдоно уу.